



АУДИТЫН КОД: САГ-2018/10/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Ахлах аудитор Р.Цолмон

Утас: 260512 Цахим хаяг: tsolmonr@audit.gov.mn

Аудитор Б.Баярмаа

Утас: 261740 Цахим хаяг: bayarmaab@audit.gov.mn

Гэрээт аудитор Д.Мөнхдэлгэр

Утас: 261740

Улаанбаатар хот



Агуулга

1	ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ.....	2
2	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ	5
3	АУДИТЫН ТАЙЛАН.....	7
3.1	Оршил.....	7
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	7
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	8
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
3.5	Дотоод хяналт.....	9
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
3.7	Шилэн дансны мэдээлэл.....	10
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	10
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	11
3.9.1	Харьяа байгууллагын санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	11
3.9.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	11
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	12
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд.....	12
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	12
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	12
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3.16	Үр өгөөжийн тооцоолол	13
4	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	14
4.1	НББ, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах талаар	15
4.2	Дотоод хяналтын талаар.....	16
5	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	17
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	17
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	18
5.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
5.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	20
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2018.04.25 № 1038
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

W10.10.10.2018Bichig_KhuregiYawsan_Bichig20180425SAG28.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

3 АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Оршил

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд тус байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд тус байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналыг боловсронгуй болгох, дотоод хяналтийн тогтолцоог бүрдүүлэх, хөрөнгийн дансны ангиллыг үнэн зөв бүртгэх талаар зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.


Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 12-ноос 2018 оны 4 дүгээр сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Р.Цолмон, аудитор Б.Баярмаа, гэрээт аудитор Д.Мөнхдэлгэр нар хариуцаж хэрэгжүүлэв.



Үндсэн хуулийн цэцийн дарга 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн ТГ-1/140 дүгээр албан бичгээр Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Үндсэн хуулийн цэцийн эрхэм зорилгыг “Үндсэн хуулийн аливаа зөрчлөөс сэргийлэх, гарсан зөрчлийг таслан зогсоож, маргааныг магадлан шийдвэрлэх замаар Үндсэн хуулийг нэг мөр сахин хэвшүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх, ажиллагаанд мэргэшил, арга зүй, хууль зүйн үйлчилгээг шуурхай үзүүлэх, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, гадаад харилцааг өргөжүүлэх, Үндсэн хуулийн шүүх хоорондын хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, үндсэн хуулийн болон бусад салбар эрх зүйн чиглэлээр онол, практикийн судалгаа хийх, мэдээлэл, лавлагаа бэлтгэх, цэцийн маргаан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх стратеги зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үндсэн хуулийн цэцийн дарга дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Үндсэн хуулийн цэц тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар Үндсэн хуулийн цэцийн даргын 2017 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг 3 үзүүлэлтээр баталгаажуулсныг дараах гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна. Үүнд:


- ✓ Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн барагдуулалт 90.0 хувь байхаар төлөвлөж, биелэлт 93.8 хувь;
- ✓ Бага суудлын хуралдаанаар шийдвэрлэсэн өргөдлийн барагдуулалт 90.0 хувь байхаар төлөвлөж, биелэлт 93.8 хувь;
- ✓ Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэн дунд, их суудлын хуралдаанаар шийдвэрлэсэн өргөдлийн барагдуулалт 90.0 хувь байхаар төлөвлөж, биелэлт 92.9 хувийн гүйцэтгэлтэй буюу 2017 онд 163 өргөдөл, мэдээлэл хүлээн авснаас 153-ийг шийдвэрлэж, бага суудлын хуралдаан 26, дунд суудлын хуралдаан 9, их суудлын хуралдаан 2, нийт 37 удаа цэцийн хуралдаан хийж, Үндсэн хуулийн цэцийн 29 магадлал, 7 дүгнэлт, 2 тогтоол гаргасан байна.

Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал, дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Үндсэн хуулийн цэцийн зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.



Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 3 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 21 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Үндсэн хуулийн цэцийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөөгүй байна.

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн санхүүгийн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэдэг “Accolous 3.0” програм хангамжийг ашиглажээ.

3.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Үндсэн хуулийн цэцийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтын нэгж алба байгуулаагүй бөгөөд байгууллагын өдөр тутмын ажилд Төсвийн ерөнхийлөн захирагч, Тамгын газрын дарга нар хяналт тавин ажилладаг байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн багцад тайлант онд хэрэгжүүлэх 3 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.


Дээрх хуулиар Үндсэн хуулийн цэцийн Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт урсгал зардалд 1,595.0 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батласан бөгөөд хөрөнгө оруулалтын зардал батлагдаагүй байна.

Батлагдсан төсвөөс 93.9 хувийг зарцуулж буюу 97.7 сая төгрөг хэмнэсэн байна. Улсын төсвийн урсгал санхүүжилт 1,595.0 сая төгрөг олгогдсоноос, 1,497.4 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийг 6.1 хувь буюу 97.7 сая төгрөгийг хэмнэж, улсын төсөвт буцаан төвлөрүүлж, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

Хүснэгт №1 Батлагдсан төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй харьцуулсан.

/сая.төг/

д/д	Зардлын ангилал	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү /+,-/
1	Цалин хөлс	942.7	942.7	-
2	НДШ	103.7	103.7	-
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21.5	21.5	-
4	Хангамжийн материал	109.2	109.2	-
5	Эд хогшил, урсгал засвар	36.6	36.6	-



Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн
2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

6	Томилолт, зочны зардал	16.8	16.8	-
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	33.0	33.0	-
8	Бараа үйлчилгээний бусад	121.2	121.2	-
9	Урсгал шилжүүлэг	210.4	112.7	97.7
	Дүн	1,595.0	1,497.4	97.7

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг энэ тайлангийн 5.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу үнэн зөв гаргаж ирүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Үндсэн хуулийн цэцийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр ил тод мэдээлж ажилласан байна. Тухайлбал:

- ✓ “Төсөв” цэсний төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан зэрэг мэдээллийг тус тус 1 удаа;
- ✓ “Төсөв” цэсний төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт; цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээг тус тус 12 удаа;
- ✓ “Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт” цэсэнд Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар хөрөнгө оруулалтын төсөв батлагдаагүй тул хөрөнгө оруулалтын талаар хамааралтай мэдээлэл байхгүй, харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр санхүүжилтийн мэдээллийг тухайн гүйлгээ гарсан сар бүр;
- ✓ “Бусад” цэсний байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллийг сар бүр мэдээлж ажилласан байна.

Үндсэн хуулийн цэцийн даргын болон Тамгын газрын шилэн дансны цахим хуудаст 2017 онд мэдээлэл байршуулсан байдлыг харуулбал:


- ✓ Үндсэн хуулийн цэцийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудаст нийт 213 мэдээлэл;
- ✓ Үндсэн хуулийн цэцийн ажлын албаны шилэн дансны цахим хуудаст нийт 148 мэдээлэл тус тус байршуулан ажилласан байна.

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Үндсэн хуулийн цэцтэй холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 3 чиглэлд эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 21 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.



Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.

3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

3.9.1 Харьяа байгууллагын санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвөөс санхүүжиж, тайлан нэгтгэдэг харьяа байгууллага байхгүй болно.

3.9.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 212.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг санхүүгийн тайланд залруулж, тус байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналыг үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналтын үйл ажиллагаанд үр нөлөөтэй гэж үзсэн дараах зөвлөмжүүдийг хүргүүлэв.

3.9.2.1 НББ, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах талаар

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д “нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд баримтлах бодлогын баримт бичгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалттай нийцүүлэн боловсруулж, мөрдөх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.9.2.2 Санхүүгийн тайлагналын талаар


Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан, тодруулгыг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу бэлтгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын баталсан холбогдох заавар журмын дагуу аудитын явцад залруулав.

3.9.2.3 Дотоод хяналтын талаар

Байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж, дотоод хяналтын алба нэгж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-т “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх,



үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.9.2.4 Үндсэн хөрөнгийн талаар

Хөрөнгийн дансанд үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, элэгдлийг хэмжээг буруу тооцоолсноос тайлант үеийн элэгдлийн зардал 25.1 сая төгрөг, өмнөх тайлант үеийн элэгдлийн зардлыг 178.1 сая төгрөгөөр тус тус дутуу бууруулсан байна.

Энэ нь УСНББОУС 17 буюу “Үндсэн хөрөнгө” стандартын 66-д “хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглахаар тооцсон хугацааны туршид сиситемтейгээр хуваарилна” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: УСНББОУС 3 буюу “Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа” стандартын 42-т “хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнийг өсөх, эсвэл цэвэр хөрөнгө/өмчийн зүйлтэй холбогдох нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийн хэмжээг өөрчлөлт гарсан тайлант үед нь холбогдох хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг эсвэл цэвэр хөрөнгө/өмчийн зүйлийг тохируулах замаар хүлээн зөвшөөрнө” гэсний дагуу санхүүгийн тайланд залруулав.

3.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байна.

3.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй тул завсрын аудитаар онцгойлон авч үзэх асуудал алга байна.

3.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 212.7 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, санхүүгийн тайланд залруулж, тус байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналын үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналтын үйл ажиллагаанд үр нөлөөтэй гэж үзэн менежментийн захидлаар 2 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.


3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас итгэл үзүүлж зөрчилгүй санал дүгнэлт өгч “Итгэмжлэл” гардуулсан тул зөвлөмж өгөгдөөгүй байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

3.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2017 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.



Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 1,421.4 сая төгрөг бөгөөд түүний 2.0 хувь 28.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулав.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 3.9-д тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 2 дугаар хэсэгт үзүүлэв.

3.16 Үр өгөөжийн тооцоолол

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар үр өгөөж бүртгэгдээгүй болно.



4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Үндсэн хуулийн цэцийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.



**4.1 НББ, санхүүгийн үйл ажиллагааг
сайжруулах талаар**

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг чиглүүлэх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д “нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг” гэж заасны дагуу байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөөгүй байна

Эрсдэлүүд

Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журам заавар зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

- Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд баримтлах бодлогын баримт бичгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалттай нийцүүлэн боловсруулж, мөрдөж ажиллах;

- Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.2 Дотоод хяналтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж, дотоод хяналтын алба нэгж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-т “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журам заавар зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

- Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, онцлогт тохирсон дотоод хяналтын чиг үүрэг бүхий алба, нэгж ажиллуулах;

- Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

5.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	44,510.2	30,216.4
МӨНГӨН ХӨРӨНГӨ	20.8	20.8
АВЛАГА	16,800.2	704.2
БАРАА МАТЕРИАЛ	27,689.2	29,491.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,883,547.6	1,626,544.1
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,883,547.6	1,626,544.1
Биет хөрөнгө	1,874,857.6	1,625,095.8
Биет бус хөрөнгө	8,690.0	1,448.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,928,057.8	1,656,760.5
НИЙТ ӨР ТӨЛБӨР	912.3	480.3
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	912.3	480.3
Өглөг	912.3	480.3
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,927,145.5	1,656,280.2
Засгийн газрын хувь оролцоо	1,927,145.5	1,656,280.2
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,015,457.9	2,015,457.9
Хуримтлагдсан үр дүн	-94,868.3	-365,733.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,556.0	6,556.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,928,057.8	1,656,760.5



5.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	840,332.1	1,595,069.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	840,332.1	1,595,069.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	924,400.4	1,680,607.0
УРСГАЛ ЗАРДАЛ	916,891.9	1,680,607.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	885,619.9	1,470,198.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	606,939.5	945,428.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,201.2	100,528.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,716.2	21,542.4
Хангамж, бараа материалын зардал	79,781.0	121,506.9
Эд хогшил, урсгал засварын зардал	1,210.5	31,849.7
Томилот, зочны зардал	12,768.1	16,760.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,799.3	32,992.1
Бараа үйлчилгээний бусад зардал	90,204.1	199,590.6
ХҮҮ	0.0	0.0
ТАТААС	0.0	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,272.0	210,408.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,508.5	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-84,068.3	-85,537.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	7,260.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-84,068.3	-92,797.1

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,011,213.8	0.0	2,011,213.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,011,213.8	0.0	2,011,213.8
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	-84,068.3	0.0	-84,068.3
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,927,145.5	0.0	1,927,145.5
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,927,145.5	0.0	1,927,145.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-178,068.2	0.0	-178,068.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,749,077.3	0.0	1,749,077.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	-92,797.1	0.0	-92,797.1
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,656,280.2	0.0	1,656,280.2

5.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/


Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	840,332.1	1,595,069.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	840,332.1	1,595,069.9
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	840,282.1	1,577,566.4
УРСГАЛ ЗАРДАЛ	840,282.1	1,577,566.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	839,282.1	1,367,158.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	594,012.7	942,692.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,395.9	103,696.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,716.2	21,542.4
Хангамж, бараа материалын зардал	79,591.0	107,213.1
Нормативт зардал	0.0	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	1,554.8	31,849.7
Томилолт, зочны зардал	12,768.1	16,760.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,399.3	32,992.1
Бараа үйлчилгээний бусад зардал	57,844.1	110,411.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000.0	210,408.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	50.0	17,503.5
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	50.0	17,503.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50.0	17,503.5
Дотоод эх үүсвэрээр	50.0	17,503.5
Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-50.0	-17,503.5
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20.8	20.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20.8	20.8

5.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ДҮН	1,595,034.4	1,497,362.0	97,672.4	93.9
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,595,034.4	1,497,362.0	97,672.4	93.9
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,595,034.4	1,497,362.0	97,672.4	93.9
Бараа ажил үйлчилгээний зардал	1,384,662.5	1,384,661.5	1.0	100.0
Цалин хөлс ба нэмэгдэл урамшуулал, НДШ	942,692.6	942,692.6	-	100.0
Үндсэн цалин	738,983.3	738,983.3	-	100.0
Нэмэгдэл цалин	158,690.0	158,690.0	-	100.0
Унаа, болон бусад нөхөн олговор	45,019.3	45,019.3	-	100.0
АО-с НД-д төлөх шимтгэл	103,696.3	103,696.3	-	100.0
Тэтгэврийн даатгал	65,988.4	65,988.6	(0.2)	100.0
Тэтгэмжийн даатгал	8,824.0	7,541.5	1,282.5	85.5
ҮОМШӨ-ний даатгал	8,144.5	9,426.9	(1,282.4)	115.7
Ажилгүйдлийн даатгал	1,885.5	1,885.4	0.1	100.0
Байгууллага төлөх ба ЭМД-ийн хураамж	18,853.9	18,853.9	0.0	100.0
Байр ашиглалттай холбоотой зардал	21,542.4	21,542.4	-	100.0
Гэрэл цахилгаан	6,566.6	10,397.2	(3,830.6)	158.3
Түлш, халаалт	10,467.3	9,111.5	1,355.8	87.0
Цэвэр, бохир ус	4,508.5	2,033.8	2,474.7	45.1
Хангамж, бараа материалын зардал	109,207.1	109,207.1	-	100.0
Бичиг хэрэг	6,227.1	6,388.5	(161.4)	102.6
Тээвэр (шатахуун)	68,500.1	65,884.6	2,615.5	96.2
Шуудан холбоо	14,908.9	15,991.4	(1,082.5)	107.3
Ном хэвлэл авах	15,345.0	16,103.5	(758.5)	104.9
Хог хаягдал устгах цэвэрлэх	590.7	677.8	(87.1)	114.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	3,635.3	4,161.4	(526.1)	114.5
Эд хогшил урсгал засварын зардал	36,573.4	36,573.4	-	100.0
Багаж, техник хэрэгсэл	378.7	5,642.4	(5,263.7)	1489.9
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	343.0	648.3	(305.3)	189.0
Урсгал засвар	35,851.7	30,282.7	5,569.0	84.5
Томилолт зочны зардал	16,760.0	16,760.0	-	100.0
Гадаад албан томилолт	4,666.1	14,837.3	(10,171.2)	318.0
Дотоод албан томилолт	12,093.9	1,922.7	10,171.2	15.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	32,993.1	32,992.1	1.0	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	30,805.2	30,804.2	1.0	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	207.9	207.9	-	100.0
Газрын төлбөр	1,980.0	1,980.0	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	121,197.6	121,197.6	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	32,105.8	32,105.8	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	89,091.8	89,091.8	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	210,371.9	210,371.9	-	100.0
Засгийн газар хоорондын шилжүүлэг	2,849.0	2,778.0	71.0	97.5



Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн
2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

	ЗГ-ын гадаад лжүүлэг	2,849.0	2,778.0	71.0	97.5
	Бусад урсгал шилжүүлэг	207,522.9	109,922.5	97,600.4	53.0
	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	197,922.9	100,322.5	97,600.4	50.7
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	9,600.0	9,600.0	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,595,034.4	1,497,362.0	97,672.4	93.9
	Төсвөөс санхүүжих	1,595,034.4	1,497,362.0	97,672.4	93.9
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		20.8		
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		20.8		

